2025

# “МАЙНКРАФТ КОНСАЛТИНГ” ХХК

# СЭЛЭНГЭ АЙМГИЙН САЙХАН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ЦАХИУРТ” ГАНТИГАН ДАЙРГАНЫ ОРД АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

## /РЕГИСТРИЙН ДУГААР: 5889103/

УЛААНБААТАР ХОТ, 2025 ОН |

## АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ..... 3
1.1. Төслийн нэр ..... 3
1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага ..... 3
1.3. Төслийн байршил ..... 3
1.4. Төслийн үйл ажиллагааны товч танилцуулга ..... 4
ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ..... 6
2.1. Төсөл хэрэгжиж буй нутгийн цаг уур, уур амьсгалын нөхцөл ..... 6
2.2. Газрын гадарга, геоморфологи ..... 6
2.3. Геологийн тогтоц, хөрс үүсгэгч эх чулуулаг ..... 8
2.4. Гадаргын болон газрын доорх ус ..... 9
2.5. Хөрсөн бүрхэвч ..... 10
2.6. Ургамлан нөмрөг ..... 11
2.7. Нийгэм эдийн засгийн хөгжил ..... 12
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ 13
3.1. Төслийн болзошгүй нөлөөллүүд ..... 13
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ ..... 16
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 17
ЗУРГАА. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 20
ДОЛОО. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 21
НАЙМ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 23
ЕС. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 24
АРАВ. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 25
АРВАН НЭГ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 27
АРВАН ХОЁР. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР ..... 28
АРВАН ГУРАВ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 31
АРВАН ДӨРӨВ. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 32
БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ ..... 33
ХАВСРАЛТ ..... 34

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршил....3
Зураг 2. Төслийн талбайн ерөнхий байдал....4
Зураг 3. Агаарын температурын жилийн явц (℃)....6
Зураг 4. Төсөл хэрэгжих талбайн өндөршил....7
Зураг 5. Төслийн талбайн геоморфологи....7
Зураг 6. Төслийн талбайн газрын гадарга....8
Зураг 7. Төслийн талбай орчмын геологийн тогтоц....9
Зураг 8. Хараа-Шарын голын сав газрын байршил....9
Зураг 9. Нөхөн сэргээгддэг нөөцийн тархалт....10
Зураг 10. Төслийн талбай орчмын хөрсний зураг....11
Зураг 11. Ургамалжлын зураг....12
Зураг 12. Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд тарих модны талбай....22
Зураг 13. Мониторингийн цэгийн байршил....30

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Талбайн солбицол....3
Хүснэгт 2. Уулын ажлын төлөвлөгөө....4
Хүснэгт 3. Хуулах шимт хөрсний хэмжээ....4
Хүснэгт 4. Хөрсний талбай, га....11
Хүснэгт 5. Төсөл хэрэгжих үеийн байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, түүний үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах нь....13
Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө....17
Хүснэгт 7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө....21
Хүснэгт 8. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө....24
Хүснэгт 9. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө....25
Хүснэгт 10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө....27
Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр....29
Хүснэгт 12. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ....31
Хүснэгт 13. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь....32
Хүснэгт 14. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал, төг....33

# НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 1.1. Төслийн нэр

"Цахиурт" гантиган дайрганы орд ашиглах төсөл

## 1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага

Төсөл хэрэгжүүлэгч: "Майнкрафт консалтинг" ХХК
Улсын бүртгэлийн дугаар: 1311015257
Регистрийн дугаар: 5889103
Хаяг: Сэлэнгэ аймаг, Сайхан сум, 1-р баг, Хөтөл, Үйлдвэрийн район-1.
Утас: 99036950

## 1.3. Төслийн байршил

"Цахиурт" гантиган дайрганы орд нь Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт орших бөгөөд 1:100 000 масштабтай байрзүйн зургийн М-48-92 тоот хавтгайд хамаарагдана. Тус орд нь Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт Сайхан сумаас зүүн хойш 35 км, Сэлэнгэ аймгийн төвөөс баруун урагш 130 км, Дархан-Уул аймгаас баруун урагш 25 км зайд оршино. Төслийн талбайн байршлыг дараах зургаар харууллаа.




**Зураг 1. Төслийн талбайн байршил**

Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгийн солбицлыг хүснэгтэд үзүүлэв

**Хүснэгт 1. Талбайн солбицол**

| № | Уртраг | Өргөрөг |
|---|---|---|
| 1 | 105° 48' 16" | 49° 21' 51" |
| 2 | 105° 48' 16" | 49° 22' 0" |
| 3 | 105° 47' 27" | 49° 22' 0" |
| 4 | 105° 47' 27" | 49° 21' 51" |
| 5 | 105° 48' 16" | 49° 21' 51" |




**Зураг 2. Төслийн талбайн ерөнхий байдал**

## 1.4. Төслийн үйл ажиллагааны товч танилцуулга

2026 онд ордын уул-техникийн нөхцөлөөс харахад уурхайн нээлтийг аль ч хэсгээс хийх боломжтой байна. Гадаргуугийн өндөржилт, тээвэрлэлтийн чиглэл зэргээс хамааран нээлтийн ажлыг +923 түвшнээс X-558121,Y-5468482 координатаас эхлүүлэхээр тооцсон байна. Нээлтээр 1.1 мян.м3 хөрс хуулж газрын гадаргын налуу хэсгийг ашиглан овоолго үүсгэх ба 5.2 мян.м3 ашигт малтмал олборлоно.

Ил уурхайн жилийн хүчин чадал болон ашиглалтын хугацаа 2026 онд ил уурхайн хүчин чадал нь жилд 50.0 мян.$м^3$ дайрга олборлохоор байна.

**Хүснэгт 2. Уулын ажлын төлөвлөгөө**

| Ашиглалтын жил | Дайрга | | Хуулах хөрс | Кхх |
|---|---|---|---|---|
| | мян.м3 | мян.тн | мян.м3 | мян.тн |
| **2026 он** | 50.0 | 140.0 | 15.1 | 0.30 |
| **Нийт** | 50.0 | 140.0 | 15.1 | 0.30 |

**Хүснэгт 3. Хуулах шимт хөрсний хэмжээ**

| Ил уурхайн эвдрэлд өртөх талбай, м2 | Овоолго | Тосгон, м2 | Бусад 10% | Нийт эвдрэлд өртөх талбай, м2 | Хуулах шимт хөрсний хэмжээ, м3 |
|---|---|---|---|---|---|
| **70,779.84** | 21,233.95 | 1,750.00 | 9,376.38 | 103,140.17 | 30,942.05 |

Өрөмдлөг тэсэлгээний ажил 2026 онд ил уурхайн хүрээн дэх чулуулгийн физик, механик шинж чанар өрмийн машины явагдах орчин нөхцөл зэргийг үндэслэн Hanjin 16BT загварын өрмийн машин сонгон авсан. 2026нд уурхайн тэсэлгээний ажлыг тэсэлгээний тусгай зөвшөөрөлтэй компаниар гэрээгээр хийж гүйцэтгүүлнэ.

Дотоод тээвэр: 2026 онд төлөвлөгөөний дагуу дунджаар 15.0 мян.м3 хөрс хуулж, 50.0 мян.м3 дайрга олборлоно.

а. Хөрс тээвэрлэлт. Уурхайн хөрс тээвэрлэлтийн дундаж зай 0.8 км байна.

б. Ашигт малтмалын дотоод тээвэр. Жилд дунджаар 50.0 мян.м3 дайргыг мөргөцгөөс шууд ачиж, бутлан ангилах хэсэг хүртэл 0.5 км зайд тээвэрлэнэ.

Овоолго дээр болон тусалж ажилд ашиглах тоног төхөөрөмж: Уурхай болон хөрсний овоолгод SD23 маркийн бульдозер туслах ажилд ZL 50E утгуурт ачигч ажиллуулахаар байна. Бульдозер нь уурхай дотор зам засах, экскаваторын сууръ бэлдэж өгөх, траншей суулгах, хөрс хуулах гэх мэт ажил гүйцэтгэхээс гадна хөрсний овоолго дээр очиж хөрс түрэх, тэгшлэх ажил хийнэ. Уурхайн туслах ажил болон бутлан ангилах хэсгийн бункер дээр Хятад улсад үйлдвэрлэсэн ZL 50E моделийн ачигчийг ажиллуулна.




| Д/д | Түвшин /м/ | Дайрга олборлолт м³ | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | B-II | C-III | C-IV | Нийт | Шимт хөрс /м³/ | Хаягдал бохирдол | Тээвэрлэлт цэвэр дайрга | Бохирдолтай чулуу овоолгод |
| 1 | 875 | 9,400 | 600 | - | 10,000 | 120 | 10 | 9,000 | 1,000 |
| 2 | 870 | 4,920 | | 80 | 5,000 | 16 | 10 | 4,500 | 500 |
| 3 | Овоолго №2 | - | - | - | - | - | - | - | 569 |
| 4 | Овоолго №3 | - | - | - | - | - | - | - | 347 |
| 5 | Бүгд | 14,320 | 600 | 80 | 15,000 | 136 | 20 | 13,500 | 2,416 |

Уурхай нь жилд 50 мян.м3 дайрга олборлох ба цагт 83 тн дайрга боловсруулах шаардлагатай болно. Дайргыг чулууг хацарт бутлуураар бутлан, шигшүүрээр шигшин, +20 мм-ээс дээш бүтээгдэхүүн дахин бутлагдан эргэлтийн ачааллаар шигшүүрт өгөгдөнө. Туузан дамжуургаар 0- 5 мм, 5-10 мм, 10-20 мм-ийн ширхэглэлийн эцсийн бүтээгдэхүүн дайрга гарна.

Цагийн бүтээмжийн тооцоо: Бутлан ангилах цех нь 2026 онд 50.0 мянган м3 дайрга боловсруулах бөгөөд өдөрт 10 цагаар 1 ээлжээр ажиллана.

# ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 2.1. Төсөл хэрэгжиж буй нутгийн цаг уур, уур амьсгалын нөхцөл

Төслийн талбайн хувьд агаарын үнэмлэхүй температур нь -39 –(+40$^0$) байдаг. Олон жилийн дунджаар 15-25$^0$ , 1-р сард олон жилийн дундажаар -20$^0$ хүйтэн байдаг. Хоногийн дундаж агаарын температур намар орой /дунджаар 10-р сарын 20-ноос 10 дугаар сарын 25-ны хооронд /0 градусаас хүйтэрч, хавар нилээд эрт /дунджаар 4 дүгээр сарын 3-5 ны хооронд/ 0 градусаас дулаарч эхлэх учраас жилийн 175-185 хоногт хүйтэн байдаг.

Жилдээ -40 градусаас хүйтэн өдрийн тоо 1-7 удаа байдгийн дотор суманд 15-20 өдөр ажиглагдана. Бэлчээрийн ургамал ургах боломжтой хугацаа нь 169-179 хоног үргэлжилнэ.




**Зураг 3. Агаарын температурын жилийн явц (℃)**

Төсөл хэрэгжих бүс нутгаар 200-275 мм хур тунадас, хойд хэсгээр 275-300 мм тунадас, тус тус ордог байна. Мөн Монголдоо хамгийн олон удаа цас шуурдаг нутаг бөгөөд жилдээ 20 өдөр цасан шурга, 28 өдөр явган цасан шуурга шуурах ба хавар намар тохиолдох магадлал өндөртэй байдаг.

## 2.2. Газрын гадарга, геоморфологи

“Цахиурт гантиган дайрга”-ны орд нь газарзүйн байршлын хувьд Хэнтий нурууны баруун урд хэсгийн дунд зэргийн уулархаг мужид хамаарагдана. Талбайн хамгийн өндөр цэг нь Цахиурт уул (1100м), дундаж харьцангуй өндөр 300-400м байна.




**Зураг 4. Төсөл хэрэгжих талбайн өндөршил**

***Геоморфологиийн хэв шинж.*** Районы болон хайгуулын талбай нь геоморфологийн мужлалын хувьд Орхон-Сэлэнгийн дунд ба нам өндөртэй уулсаас тогтсон. Тухайн нутгийн гадаргуугийн хэлбэр тогтоц үүсэн бүрэлдэхэд геологи, тектоникийн болон гадаад дотоод хүчин зүйл тухайлбал хурдас хуримтлал, идэгдэл, элэгдэл ба тектоникийн хөдөлгөөний үйл ажиллагаа гол үүрэг гүйцэтгэсэн.




**Зураг 5. Төслийн талбайн геоморфологи**

**Элэгдэл тектоникийн рельеф**: Орхон, Сэлэнгийн нутаг нь тектоник-элэгдлийн гадаргуу нэлээд хэмжээгээр үүсэж тогтсон байдаг. Тухайлбал Дарханы районд Их, Бага Номгон, Санчир,

Бууралт уул зэрэг газрууд дунд өндөрлөгтэйд хамаарагдана. Эдгээр уулс нь гуу жалга ихтэй, V хэлбэрийн хөндий үүсгэн тогтжээ.

Өмнөд, зүүн өмнөд хэсэгт эгцдүү хажуутай хадархаг оройтой нарийвтар хяр үүсгэн тогтсон их, бага Номгон уул Сэртэн уулын гадаргуу хүчтэй хэрчигдэлд орж V хэлбэрийн хөндий үүсэж тэдгээрийн өргөн дээд хэсэгтээ 50-100м, нам хэсэгтээ 200-400м өргөн хөндий үүсгэсэн байдаг. Судалгааны дүүргийн ихэнх хэсэг нь нам өндөрлөг уулст хамаарагдана.



**Зураг 6. Төслийн талбайн газрын гадарга**

Нутгийн үнэмлэхүй өндөр 900-1100м, харьцангуй 200-300м өндөрт налуу хажуутай мөлгөрдүү оройтой, тэгшивтэр хярын шугамтай, сул хэрчигдэлтэй гүн биш хуурай жалгаас бүрдсэн дөрөвдөгчийн хурдсаар хучигдана.

## 2.3. Геологийн тогтоц, хөрс үүсгэгч эх чулуулаг

Талбай нь региональ структурын хувьд хойд Монголын атираат мужийн Тариат Дарханы өргөгдлийн Дархан дахь хэсэгт хамаарагдана. Дарханы дүүргийн хэмжээнд тархсан чулуулаг протерозой-доод мезозой, доод перм, дөрөвдөгчийн хурдас өргөн тархсан байдаг.




**Зураг 7. Төслийн талбай орчмын геологийн тогтоц**

## 2.4. Гадаргын болон газрын доорх ус

***Гадаргын усны горим.*** Монгол орны гол, мөрөн, түүний сав газрын хэмжээ, байгалийн нөхцөл, урсац бүрэлдэх зүй тогтол, нөөцийн хуваарьлалт, байгалийн болон засаг захиргааны хил хязгаарыг үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 332 дугаар тушаалаар Монгол орны нутаг дэвсгэрийг усны 29 сав газарт хувааж, хил хязгаарыг нь тогтоож өгсөн байдаг бөгөөд тус төслийн талбай нь Хараа-Шарын голын сав газарт хамаарч байна. Сав газрын байршлыг дараах зургаар харууллаа.




**Зураг 8. Хараа-Шарын голын сав газрын байршил**

Сэлэнгэ аймгийн голуудаас Хиагт гол маш бохир, Бууръ гол бага бохирдолтой, Сэлэнгэ мөрөн, Зэлтэр, Орхон, Туул, Хараа, Хүдэр голууд цэврийн ангилалд, Бургалтай, Ерөө, Бугант голууд маш цэврийн ангилалд хамаарагдаж байгаа нь Байгаль орчны сайд, Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын сайдын 1997 оны 143/а/352 тоот хамтарсан тушаалын 3 дугаар хавсралтад заасан гадаргын усны цэврийн зэргийн ангиллын нормыг ашиглавал адил гарч байна.

***Төслийн талбайн гидрогеологийн нөхцөл.*** Тус бүс нутгийн гүний ус нь сийрэг мезокайнозоны чулуулгийн цогц ба дөрөвдөгч аллювиал хурдаст хамаарна. Гүний усны үндсэн хэсэг нь инфильтрацийн үүсэлтэй бөгөөд тиймдээ ч түүний түвшингийн горим нь агаар мандлын хур тунадаснаас шууд хамааралтай. Үндсэн чулуулгийн усжилт нь нийт талбайгаар жигд бус бөгөөд уулын чулуулгийн ан цавт байдлаас хамаарна. Дөрөвдөгч хурдсын нимгэн бүрхүүл доорх хөндийд орших үндсэн чулуулаг болон тектоник эвдрэлтэй газарт ерөнхийдөө хамгийн их ан цав оршино.




**Зураг 9. Нөхөн сэргээгддэг нөөцийн тархалт**

Нөхөн сэргээгддэг нөөц гэж жил бүр хур тундасын нэвчилт, гадаргын усны нэвчилт шүүрэлт, хажуугийн урсацын нөлөөгөөр дахин бүрэлдэх боломжтой усны хэмжээг хэлнэ. Нөхөн сэргээгддэг нөөцийн тархалтын зургаас харахад төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь газрын доорх урсацын түвшин 5 мм/жилд-ээс бага хэсэгт хамаарч байна.

## 2.5. Хөрсөн бүрхэвч

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Цахиуртын гантиган дайрганы ордын талбай орчмын эзэмшлийн 27.47 га талбайгаас техносол буюу эвдрэлд орсон газар 1.93 га талбай эвдэрч доройтсон байна. Уулын чулуу бутлах, олборлох үйл ажиллагаатай холбоотойгоор байгалийн генетик үе давхарга алдагдаж, хөрсөн бүрхэвч байхгүй болсон байна.




**Зураг 10. Төслийн талбай орчмын хөрсний зураг**

Уулын ажил хийгдсэн газар өмнө нь Чулуурхаг хархүрэн, Сайргархаг хархүрэн хөрс тогтворсон байжээ. Уулын чулууны орд газар учир илүүтэй Чулуурхаг хархүрэн хөрстэй газраа түшиглэн үйл ажиллагаа явуулж байна.

**Хүснэгт 4. Хөрсний талбай, га**

| Дэс дугаар | Ашиглалтын хэлбэр | Талбайн хэмжээ, га |
|---|---|---|
| **1** | Сайргархаг  хархүрэн хөрс | 12.69 |
| **2** | Сайрын хөрс | 0.34 |
| **3** | Эвдэрсэн талбай | 1.93 |
| **4** | Чулуурхаг хархүрэн | 12.5 |
| **5** | Төслийн талбайн гаднах эвдэрсэн газар | 1.25 |

## 2.6. Ургамлан нөмрөг

Ургамалжлын хувьд Монгол Дагуурын ойт хээрийн болон хээрийн бүлгэмдэлтэй бөгөөд нам уулс, өндөрлөг толгодын ар хажуугийн дээд хэсгээр нугажуу хээрийн улалж-алаг өвс-үетэнт бүлгэмдэл бүхий сөөгөн ширэнгэ тохиолдоно. Хэнтийн тайгын өмнөд зах болович тайгын ойгүй, алаг өвст, улалжийн сөөгт, шинэсэн, хус- шинэсэн ой, шинэс – хусан тайгархаг ой тохиолдоно. Ойн бүслүүрт голуудын эх, нарийн аманд торлог элбэг тохиолддог. Монгол оронд хязгаардмал тархалттай байдаг нугын хээрийн сөөгөн боролзгонот, алаг өвст, зогдор улалжит, зүр өвст, байгалийн хялганат зэрэг нугын хээрийн бүх хэвшлүүд байдаг.

Хээрийн ургамалжил нь байрлал, зүг зовхисын ялгаа, өндрийн түвшнээс хамааран дэд хэв шинжийн түвшинд босоо бүсчлэл үүсгэнэ.

Нутгийн төв хэсгээр нам уулс, долгиорхог тал хөндий хослон таарaлдах бөгөөд энд уулын хээрийн үндсэн төрхийг илэрхийлэгч хялгана, ботууль, алаг өвст, үетэнт хээр, нам хотос хөндийгөөр биелэг дааган сүүл – алаг өвс, жижиг үетэнт алаг өвст уулын хээр, харин чийг сайтай нам хотос хоолой, булаг шанд, гол горхи жижиг нуурын хөндийгөөр татмын нугын ургамалжил

болох ширэг улалж, алаг өвс шивэлз зонхилсон цахидаг, улаантолгой, дэрст эвшил, хэвшилүүд түгээмэл тохиолдоно.

Төслийн талбай болон тухайн орчмын нутаг дэвсгэр нь ургамлын экологи, тархах ургамлан нөмрөгөөрөө өндөр уулын хээр, уулын хээрийн ургамалжилтай бөгөөд бүхэлдээ 2 хэвшилд хамаарах 3 бүлгэмдэл тархсан байна.




**Зураг 11. Ургамалжлын зураг**

## 2.7. Нийгэм эдийн засгийн хөгжил

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын төв Хөтөл хот нь 1984 онд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар Дархан хотын Хөтөл хороо нэртэйгээр анх байгуулагдсан. Монгол Улсын Их Хурлын 1994 оны 35-р тогтоолоор Хөтөл хороог Сэлэнгэ аймагт харъяалуулж, Засгийн газрын 1994 оны 128-р тогтоолоор аймгийн зэрэглэлтэй хот болгосон. Улсын Их Хурлын 1999 оны 22-р тогтоолоор Сайхан сумын төвийг Хөтөл хотод шилжүүлсэн. Хөтөл хот нь Улаанбаатар хотоос хойш 260 км, Сүхбаатар хотоос баруун урагшаа 163 км, Дархан-Уул аймгаас баруун тийш 58 км, Орхон аймгаас зүүн тийш 148 км зайтай оршдог. Хөтөл, Гавшгай, Номгон, Дөмбөн гэсэн 4 багийн нийт 2834 өрхөд 9204 хүн амьдардаг. Хүн амын тоогоор Сэлэнгэ аймгийн 17 сумаас эхнээсээ 3-д, газар нутгийн хэмжээгээр 11-д ордог, төв зам, төмөр зам дагуу байрлах, дэд бүтэц сайтай, газар тариалан, үйлдвэрлэл хослон хөгжсөн онцлогтой Сэлэнгэ аймгийн баруун бүсийн 5 сумдын төв юм.

# ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

## 3.1. Төслийн болзошгүй нөлөөллүүд

Байгалийн нөөцийг ашиглан үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх, уурхайн олборлолт явуулах үед орчны төлөв байдал, орон нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлж болох нөлөөллүүдийн хэлбэр, тэр нь эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх хэсгийг болон нөлөөллийн үргэлжлэх хугацаа, түүний эрчим зэргийг тодруулахын тулд магадлан жагсаах аргыг хэрэглэн төслийг хэрэгжүүлсэнээр байгаль орчны төлөв байдал болон орон нутгийн нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийн үнэлгээг магадлан жагсаах аргаар доор үзүүлэв.

**Хүснэгт 5. Төсөл хэрэгжих үеийн байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, түүний үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах нь**

| Байгаль орчны үзүүлэлт | шууд | шууд бус | өөрөө зохицуулагдах | богино хугацааны | урт хугацааны | буцаж нөлөөлөх | буцалтгүй нөлөөлөх | хүчтэй | дунд зэрэг | бага зэрэг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт | | | | | | | | | | |
| Газрын дээрхи урсацын өөрчлөлт | | x | | | x | | x | | | x |
| Газрын доорх усны чанарын өөрчлөлт | | x | | | x | | x | | | x |
| Гадаргын усны урсацын өөрлөлт | | x | | | x | | x | | | x |
| Ургамлын бүтцийн өөрчлөлт | x | | | | x | | x | | x | |
| Хөрсний элэгдэл, эвдрэл | x | | | | x | | x | | x | |
| Геологийн тогтоцын өөрчлөлт | x | | | | x | | | | | |
| Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт | x | | | | x | | x | | x | |
| Уур амьсгалын (бичил) өөрчлөлт | Нөлөөлөл байхгүй | | | | | | | | | |
| 2. Байгалийн нөөц, ашиглалт | | | | | | | | | | |
| Газрын гадаргын нөөц баялаг | x | | | | x | | x | | x | |
| Бэлчээрийн байдал | x | | | | x | x | | | x | |
| Эрдэс түүхий эдийн нөөц | x | | | x | x | | | | x | |
| Эрчим хүчний нөөц | x | | | | | | | | x | |
| 3. Байгаль, орчны өөрчлөлт | | | | | | | | | | |
| Агаарын бохирдол | | x | | x | | | x | | | x |
| Ундны усны чанар, хэмжээ | x | | | x | | | | | | x |
| Хөрсний эвдрэл, бохирдол | x | | | | x | x | | x | | |
| Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх | Нөлөөлөл байхгйүй | | | | | | | | | |
| Дуу чимээ, шуугианы нөлөө | x | | | x | | | | | | x |
| 4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл | | | | | | | | | | |
| Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх | x | | | | x | | x | x | | |
| Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх | x | | | | x | | x | x | | |
| Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх | Нөлөөлөл байхгүй | | | | | | | | | |
| Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх | Нөлөөлөл байхгүй | | | | | | | | | |
| Археологи, палентологийн олдворт нөлөөлөх | Нөлөөлөл байхгүй | | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5. Нийгэмд үзүүлэх нөлөө | | | | | | | | | | |
| Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх | x | | | | x | | | | | x |
| Хүн амын орлого өөрчлөгдөж нэмэгдэх | x | | | | x | | | | | x |
| Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх | Нөлөөлөл байхгүй | | | | | | | | | |
| 6. Эдийн засаг, байгаль орчин | | | | | | | | | | |
| Татварын орлого өөрчлөгдөх | x | | | x | | | x | | | x |
| Бүс нутгийн орлого нэмэгдэх | x | | | x | | | x | | | x |
| Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох | | x | | x | | | x | | | x |
| Ажлын байр нэмэгдэх | x | | | x | | | x | | | x |
| Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх | | x | | | x | | | | x | |
| 7. Бусад нөлөөлөл | | | | | | | | | | |
| Хог хаягдлаар хөрс, ус бохирдох | | x | | | x | x | | | | x |
| Шороон зам харилцаа, уурхайн машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх | x | | | | x | | x | | | x |
| Дүн | 19 | 7 | 0 | 8 | 18 | 3 | 15 | 3 | 8 | 14 |

Эдгээр болзошгүй нөлөөллүүдийг хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмээр нь тодруулбал:

*Шууд нөлөөлөл.* Болзошгүй нөлөөллийн 19 (20%) нь шууд нөлөөлөлд хамрагдаж байна. Барилга байгууламж барихын тулд хөрс хуулах, хөндийн хуурай сайрын хэмжээ чанарт өөрчлөлт оруулах, геологийн тогтоцыг нь шууд эвдэж өөрчлөх, газрын гадаргын нөөц баялагт хомсдол үүсгэх нэг дор дизель хөдөлгүүртэй олон механизм төвлөрч ажиллах зэргээс шалтгаалж экологийн тухайн орчны системд нөлөөлөх, байгалийн тэнцвэр, унаган төрх байдал, ландшафтад сөрөгөөр нөлөөлөх муу талтай. Гэхдээ төсөл хэрэгжсэнээр орон нутгийн орлого нэмэгдэх, улс орны эдийн засгийн сан хөмрөгийг нэмэгдүүлэх зэрэг сайн нөлөөтэй.

*Шууд бус нөлөөлөл.* Уг төслөөс нийт болзошгүй нөлөөллийн 7 (7.3%) нь шууд бус нөлөөлөлд хамрагдаж байна. Нэг дор олон хүнд машин механизм зэрэг ажилхад дуу чимээ ихсэх зэрэг нөлөөлөл хамаарч байна Эдгээрийн дуу чимээний улмаас ойр орчмын ан амьтад үргэн дайжих магадлал өндөртэй юм.

*Өөрөө зохицуулагдах нөлөөлөл.* Төслийн үйл ажиллагаанаас өөрөө зохицуулагдах нөлөөлөл байхгүй байна.

Богино хугацааны нөлөөлөл. Уг төслөөс нийт болзошгүй нөлөөллийн 1 (4,34%) нь буюу бэлчээрийн байдлын нөлөөлөл богино хугацааны нөлөөлөлд орж байна.

*Урт хугацааны нөлөөлөл.* Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн 18 (18,94%) нь урт хугацааны нөлөөлөлд орж байна. Урт хугацааны нөлөөлөлд ургамлын бүтцийн өөрчлөлт, хөрсний элэгдэл, геологийн тогтоцын өөрчлөлт, гадаргын нөөц баялаг, эрдэс түүхий эдийн нөөц, байгалийн унаган төрх өөрчлөгдөх ландшафтын өнгө төрх өөрчлөгдөх гэх мэт нөлөөллүүд хамаарна. Иймээс байгалийн унаган төрхийг алдагдуулсаны дараа эргүүлж нөхөн сэргээх ажлыг маш нарийн дэс дараалалтай хийх шаардлагатай байна.

*Нөлөөллийн эрчим*. Ургамлын бүтцийн өөрчлөлт, хөрсний элэгдэл эвдрэл, эрдэс, түүхий эдийн нөөц хөрсний эвдрэл бохирдол зэрэг нь хүчтэй сөрөг нөлөөллөлд хамрагдаж байгаа учир байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд энэ хүчтэй нөлөөлөлд орсон объектийг хэрхэн сэргээх талаар тодорхой тусган, үйдвэрлэлийн явцад мөрдлөг болгон ашиглах шаардлагатай байна.

Үүний зэрэгцээ хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх, агаарын бохирдол, бэлчээрийн байдал, ургамлын бүтцийн өөрчлөлт, гадаргын нөөц баялаг, байгалийн унаган төрхийн өөрчлөлт, ландшафтын хэлбэр өнгө өөрчлөгдөх орон нутгийн орлого нэмэгдэх, ядуурлыг бууруулахад дэмжлэг болох, шороон зам харилцаа, машин механизмын хөдөлгөөн шилжилтээс борж хөрс эвдрэх, ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй муухай үнэр гарах, шавж үржих, хүчтэй салхи, уруйн үер зэрэгт эрчимтэй нөлөөлнө. Учир нь байгаль орчны хүчин зүйлүүд нь өөрөө нөхөн сэргэх чадвар маш муу байдаг.

# ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт байрлах “Цахиурт гантиган дайрганы орд ашиглах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг төслийн технологи ажиллагааны онцлогтой нь уялдуулан ОУ-ын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн гол болон болзошгүй нөлөөллийг тодорхойлох арга, аргачлалын дагуу байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг тус бүрд нь авч үзсэний үндсэн дээр байгаль орчныг хамгаалах бусад багц хууль, холбогдох журам, зааврын дагуу хийж гүйцэтгэсэн болно.

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар Монгол Улсын хуулиуд, шинээр гарч буй шаардлагатай уялдан байнга шинэчлэгдэж байх баримт бичиг төдийгүй төслийн хэрэгжилтийн үе шатанд байгаль хамгаалах, болзошгүй сөрөг нөлөөллийг тухай бүр нь бууруулж нөхөн сэргээх зорилтыг хангах үүрэгтэй юм.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь байгаль орчны нарийвчилсан үнэлгээнд тусгасан байгаль орчны бүрэдэхүүн хэсэгт нөлөөлөх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлж, тухайн жил бүр мөрдөн ажилладаг байгаль орчныг хамгаалах, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оршино.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго нь төслийн төгсгөлийн ажлын үе шатанд байгаль орчинд учруулах гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлж, сөрөг нөлөөллөөс урьдчилсан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, зардал, хариуцах эзний хамтаар төлөвлөн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахад чиглэнэ.

***Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт:***

- Монгол улсын холбогдох хууль тогтоомжуудыг мөрдөж ажиллах
- Цаашид ашиглах шаардлагагүй хөндөгдсөн талбайнуудыг тухай бүрд нөхөн сэргээж, орон нутагт хүлээлгэж өгөх;
- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж, компанийн чадамжийн хэмжээнд хувь нэмрээ оруулах;
- Батлагдсан БОМТ 2026-г хамгийн багадаа 90%-ийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлэх;
- Хүрээлэн буй орчны талаар ажилтнуудын мэдлэгийг дээшлүүлэх;
- Байгаль орчны мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх;
- Төрийн захиргааны байгууллагууд болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын хяналт шалгалтаас гарах зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх;

## ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад төслийн үйл ажиллагаанаас тухайн нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган 2026 онд хэрэгжүүлэх байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

**Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Нэгжийн өртөг /төг/ | Тоо, хэмжээ | Нийт зардал /төг/ | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ***Агаар орчин*** | | | | | | | | |
| 1 | Төсөлд ашиглагдах хүнд даацын машин механизмаас гарах хорт хий болох нүүрс хүчлийн хий, бензоприн, нүүрсустөрөгч зэрэг хорт нэгдлүүд агаарын чанарт сөргөөр нөлөөлж, агаарыг бохирдуулах | Төслийн хүрээнд ажиллах машин техникийн бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгаж, зориулалтын газар засвар үйлчилгээг хийж техникийн засвар үйлчилгээ хийсэн паспортыг боловсруулж, хөтлөх, | Төслийн талбайд ашиглагдаж буй машин техник | Үйл ажиллагааны зардал | | | | MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дах хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5885-2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS ISO 3929:2014 Автотээврийн хэрэгсэл. |
| 2 | Тээврийн хэрэгсэл, хүнд даацын машин механизмын хөдөлгөөний нөлөөгөөр тоосжилт үүсэж агаарын чанар сөргөөр нөлөөлөх | Төслийн талбай орчмын авто машины хөдөлгөөнд хяналт тавьж, хурдны хязгаар тогтоох, шаардлагатай бол хурдны хязгаарын тэмдэг, тэмдэглээ байрлуулах | Төслийн талбай, гадаад дотоод тээврийн зам | Үйл ажиллагааны зардал | | | | |
| 3 | Төслийн үйл ажиллагаа болон задгай талбай, машин техникийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэж агаарын орчныг бохирдуулах | Уурхайд ажиллах ажилчдыг тоосны нөлөөллөөс хамгаалах, машин техникийн дотоод орчны битүүмжлэлийг сайжруулах, хөдөлмөрийн аюулгүй байдлаар хангах | Ажлын талбайд | Үйл ажиллагааны зардал | | | | |

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Нэгжийн өртөг /төг/ | Тоо, хэмжээ | Нийт зардал /төг/ | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ***Хөрсөн бүрхэвч*** | | | | | | | | |
